



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/11

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд
зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.6, 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын 12 дугаар ангийн сурагчдын давтлагын цагийг Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/180 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу 2021 оны 01 дүгээр сарын 18-ний өдрөөс зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, худалдаа үйлчилгээний төвүүдийн дотор талын ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Баян-Өндөр сумаар дамжин Улаанбаатар хот, аймгийн бусад сумдын чиглэлд явдаг гол замуудын хяналтын цэгийг 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 09:00 цагаас буулгахыг сумын Засаг дарга (С.Чулууншагай)-д үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай" А/05 дугаар захирамжийн 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ